



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан.

Аудитын код: ХЭА-2026/005/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар

Утас: 70562112

Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа

Утас: 99775390

Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Х.Еркегүл

Утас: 99040705

Цахим хаяг: erkegulkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан ллага түүний үйл ажиллагаа	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13
3.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт	13
3.1.1 Төлбөрийн акт.....	13
3.1.2 Албан шаардлага	13
3.1.3 Зөвлөмж	13
3.2 Тус сумын харьяа орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт.	14
3.2.1 Орон нутгийн байгууллагуудад илэрсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт:.....	14
3.2.2 Улсын төсвийн байгууллагуудад илэрсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт: нутгийн байгууллагуудад илэрсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт:	15
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОХНСАХЗ	Байгал орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчид аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 502

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 150.4 сая төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвдөхдөө он дамжуулан хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний санхүүжилтийг тайлант онд төсөвт өртгийг тэнцүү хувааснаас багагүй байхаар төлөвлөн батлаагүй;
- ✓ Орон нутгийн төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, биелэлтэд хяналт тавьж ажиллаагүйгээс үйл ажиллагааны орлого, түгээмэл тархацтай ашигт

- малтмал ашигласны төлбөр, газрын төлбөр, торгуулийн орлого, бусад орлого зэрэг нийт 8 нэр төлрийн орлогын төлөвлөгөөг дутуу бүрдүүлсэн;
- ✓ Тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж ажиллаагүй;
 - ✓ ЗДТГ нь эд хөрөнгийн тооллогыг чанаргүй хийж, тооцоо бодож үлдэгдлийг баталгаажуулаагүй, бараа материалын тайлан гаргаагүй, ОНХС нь өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй;
 - ✓ ИТХ, ЗДТГ нь анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэл тайланд тусгасан, төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж төсвийг зориулалт бусаар зарцуулсан, цалин, үр дүнгийн урамшуулал илүү олгосон зэрэг зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3-д “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 29 дүгээр зүйлийн 29.3.5-д “шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах”, 57 дугаар зүйлийн 57.3-т “Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна”

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”;

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 3.3.4.2-д “шинээр эхлэх барилга байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөр, 23 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,956.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 2,059.7 сая төгрөгийг урсгал зардалд, 521.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 214.4 сая төгрөгийг эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар төлөвлөснөөс 2,582.3 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 87.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аудитын гол асуудал

Жаргалтхаан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 213.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 63.2 сая төгрөгийн алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 43.4 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгч, 101.0 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага хүргүүлж, 1.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо.

Орон нутгийн төсөвт 725.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 819.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг нийт дүнгээр 94.6 сая төгрөгөөр буюу 13 хувиар давуулан биелүүлсэн боловч татварын төрлөөр авч үзвэл 8 төрлийн татварын орлогын төлөвлөгөө 43.1 сая төгрөгөөр дутуу биелсэн байна.

Давж биелсэн татварын дийлэнх хувийг цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, ан амьтны нөөц ашигласны төлбөр эзэлж байна. Иймд дээрх 2 төлийн татварыг нэмэгдүүлж үндэслэлтэй төлөвлөх нь зүйтэй.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж ирүүлэх үүрэгтэй боловч 54.5.4-д “Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан” гэж заасны дагуу тайланг бэлтгэж ирүүлээгүй байна. Иймд дараагийн аудитад санхүүгийн тайлангийн иж бүрдлийг бүрэн бэлтгэж ирүүлэх шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(Мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		602,730.18	881,094.94
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	297,215.62	483,264.23
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	161,169.32	238,544.92
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	130,345.24	157,785.79
5	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	14,000.00	1,500.00
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,077,968.48	3,682,617.21
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,077,968.48	3,682,617.21
8	1.2.2.02 Биет хөрөнгө		2,025,482.48	2,630,131.21
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	1,052,486	1,052,486
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		3,680,698.65	4,563,712.15
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		0.00	129,275.40
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		0.00	129,275.40
13	2.1.1.03 Өглөг		0.00	129,275.40
14	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,680,698.65	4,434,436.75
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		3,680,698.65	4,434,436.75
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		455,561.00	455,561.00
17	2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/		22,950.00	22,950.00
18	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		3,117,292.97	3,871,031.07
19	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		84,894.68	84,894.68
20	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		3,680,698.65	4,563,712.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(Мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		2,986,732.07	3,668,769.02
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		716,861.15	744,842.10
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		420,372.88	449,770.52
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		420,372.88	449,770.52
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		36,772.52	69,521.49
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		259,715.76	225,550.09
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	527,400.22	2,923,926.92
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.00	1,429,952.38
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,742,470.70	0.00
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,251,612.74	2,614,028.28
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		2,244,612.74	2,614,028.28
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,174,464.81	2,613,028.28
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		698,873.31	892,565.84
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		88,288.95	108,666.74
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		577,641.65	604,625.17
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		100,319.52	76,927.22
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал		8,833.30	18,679.20
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		19,717.55	41,325.34
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		20,844.00	29,300.00
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		331,307.03	413,566.15
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		328,639.51	427,372.62
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		70,147.93	1,000.00
23	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		7,000.00	0.00
24	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		735,119.33	1,054,740.74
25	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		544,629.84	301,002.64
26	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-544,629.84	-301,002.64
27	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		190,489.49	753,738.10

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,480,259.16		3,480,259.16
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,480,259.16		3,480,259.16
3	1.1.1.1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	9,950.00		9,950.00
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	190,489.49		190,489.49
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,680,698.65		3,680,698.65
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,680,698.65		3,680,698.65
7	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,680,698.65		3,680,698.65
8	1.7 Тайлант үеийн үр дүн	753,738.10		753,738.10
9	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,434,436.75		4,434,436.75

.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан ллага түүний үйл ажиллагаа

(Мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12- р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,699,814.95	2,940,570.41
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	716,861.15	744,842.10
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	420,372.88	449,770.52
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	36,772.52	69,521.49
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	259,715.76	225,550.09
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	47,870.87	48,193.43
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	23,289.17	23,209.95
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	188,555.72	154,146.71
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	229,776.93	2,195,728.32
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	229,776.93	289,237.64
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.00	1,429,952.38
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	476,538.30
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,753,176.88	0.00
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,976,577.49	2,181,291.50
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,976,577.49	2,181,291.50
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,902,299.56	2,146,003.97
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	748,849.58	961,959.19
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,570.00	111,159.44
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	569,456.43	606,487.17
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	67,681.18	61,975.40
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	1,698.75	1,807.00
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	32,671.05	41,753.84
23	1.1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал	20,844.00	25,700.00
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	276,974.47	272,326.04
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	82,554.11	62,835.90
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,277.93	35,287.53
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	723,237.46	759,278.91
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	599,871.24	493,830.30
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	599,871.24	493,830.30
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	599,871.24	493,830.30
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-599,871.24	-493,830.30
32	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	79,400.00
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	-79,400.00
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	123,366.22	186,048.61
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	173,849.40	297,215.62
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	297,215.62	483,264.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,661,008.70	2,767,538.24
2	3.1.01.1.1 Татварын орлого	620,118.20	744,842.10
3	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	391,000.00	449,770.52
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	391,000.00	449,770.52
5	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	280,000.00	330,438.90
6	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	58,000.00	57,330.81
7	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	50,000.00	60,293.77
8	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	3,000.00	1,707.04
9	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	64,500.00	69,521.49
10	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	17,000.00	18,921.39
11	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	2,500.00	2,040.00
12	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	45,000.00	48,560.10
13	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	164,618.20	225,550.09
14	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	52,500.00	48,193.43
15	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	8,000.00	12,573.33
16	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	4,500.00	2,065.00
17	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	40,000.00	33,555.10
18	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	25,000.00	23,209.95
19	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	25,000.00	23,209.95
20	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	87,118.20	154,146.71
21	3.1.01.1.1.8.3.01 Ойн нөөц ашигласны төлбөр	3,000.00	27,939.54
22	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	84,118.20	125,280.00
23	3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.00	927.16
24	3.1.01.1.2 Татварын бус орлого	2,040,890.50	2,022,696.14
25	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	170,859.80	152,665.44
26	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	100,000.00	73,215.50
27	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	65,859.80	77,286.34
28	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	0.00	445.00
29	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	5,000.00	1,718.60
30	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	1,393,492.40	1,393,492.40
31	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	1,393,492.40	1,393,492.40
32	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	476,538.30	476,538.30
33	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	476,538.30	476,538.30
34	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	542,398.10	2,724,181.43
35	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	-193,629.20	2,170,859.13
36	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,211,725.10	2,024,628.23
37	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	907,278.10	889,121.62
38	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	432,324.10	423,960.64
39	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	310,531.00	314,145.66
40	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	4,392.50	9,237.00
41	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	74,230.50	57,828.30
42	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	85,800.00	83,950.02
43	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,409.80	111,159.44
44	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	77,118.60	75,108.09
45	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	9,072.70	8,830.10
46	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	4,536.40	4,996.80
47	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	4,536.40	4,415.05
48	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	18,145.70	17,809.40

49	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	633,572.90	606,487.17
50	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	89,444.50	68,681.17
51	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	512,757.40	506,435.00
52	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	31,371.00	31,371.00
53	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	61,843.70	49,082.38
54	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	4,910.60	4,091.10
55	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	44,000.00	35,030.00
56	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,588.50	5,075.38
57	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,563.80	564.00
58	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,780.80	4,321.90
59	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	1,807.10	1,807.00
60	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,807.10	1,807.00
61	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	68,121.90	61,263.84
62	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	19,505.80	19,485.00
63	3.1.01.2.1.1.6.03 Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943.10	536.00
64	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	47,673.00	41,242.84
65	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	32,589.00	25,700.00
66	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	32,589.00	25,700.00
67	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	320,850.70	219,623.90
68	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	315,533.80	216,013.84
69	3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	961.70	0.00
70	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	1,014.30	957.25
71	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	536.40	487.55
72	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношлогоо	245.60	176.00
73	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,595.40	1,182.50
74	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	963.50	806.76
75	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	72,251.90	60,382.90
76	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	58,811.00	49,638.50
77	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,440.90	10,744.40
78	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-2,405,354.30	146,230.90
79	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-2,414,435.80	141,890.90
80	3.1.01.2.1.4.1.03 Төсвийн санхүүжилт	-2,414,435.80	141,890.90
81	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	9,081.50	4,340.00
82	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,081.50	4,340.00
83	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	521,605.80	473,922.30
84	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	521,605.80	473,922.30
85	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	214,421.50	79,400.00
86	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	214,421.50	79,400.00
87	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	2,118,610.60	43,356.80
88	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-2,118,610.60	-43,356.80
89	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-2,118,610.60	-43,356.80
90	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	295,825.33
91	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	481,073.04

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Мянган төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	36,459.98
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	36,459.98
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	36,459.98
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	36,459.98
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	36,459.98
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,866.98
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	26,593.00
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,512.45
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	5,512.45
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,512.45
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	2,561.45
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	2,561.45
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	100.00
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100.00
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	2,851.00
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	2,851.00
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	30,947.53
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(30,947.53)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(30,947.53)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 67,213.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,783.1 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 20,000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 43,430.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлэв. Үүнд:

- Замд яваа мөнгөн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсныг аудитын явцад санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулав;

3.1.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

3.1.2 Албан шаардлага

- Шинээр эхлэх 48 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Гүн өрмийн худгийн цооног" төсөл, арга хэмжээг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар он дамжуулан хэрэгжүүлэхээр төлөвлөхдөө санхүүжилтийг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багаар тооцож төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д "шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;" , Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 3.3.4.2-д "шинээр эхлэх барилга байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

3.1.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь авч үзэхэд үйл ажиллагааны орлого, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, газрын төлбөр, торгуулийн орлого, бусад орлого зэрэг 8 нэр төлрийн орлогыг нийт 43,157.9 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Өгсөн зөвлөмж: Татварын орлогыг үндэслэлтэй төлөвлөж, биелэлтэд хяналт тавин нэр төрөл бүрээр бүрэн төвлөрүүлж ажиллах.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад

ирүүлнэ.” гэсэн заалтын дагуу төлөвлөгөөг 1 сарын дотор, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлнэ.

3.2 Тус сумын харьяа орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт.

Жаргалтхаан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн төсвийн 2 байгууллага, 1 төрийн сан, 3 тусгай сан, улсын төсвийн 4 байгууллагын тогтмол зардал, орон нутгийн өмчит 1 нийт 11 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад санал дүгнэлт гаргаж 6 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэв.

Аудитад хамрагдсан Засаг даргын тамгын газарт аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж “Хязгаарлалттай” дүгнэлт, Эрүүл мэндийн төвд “Платиниум прогресс аудит” ХХК аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт, Хүүхдийн цэцэрлэг, ЕБС-д “Ари файнэнс аудит” ХХК аудит хийж тус тус “Өөрчлөлтгүй” дүгнэлт гаргасан байна.

3.2.1 Орон нутгийн байгууллагуудад илэрсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт:

Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 157,208.1 мянган төгрөгийн 14 алдаа, зөрчил илэрснээс 70,233.1 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 1,124.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 81,048.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлага, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил давтагдсан 4,802.0 мянган төгрөгийн зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах 1 албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

Засаг даргын тамгын газар:

- ✓ Аудитаар нийт 39,060.5 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрснээс 5,334.0 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 1,124.5 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 27,800.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 4,802.0 мянган төгрөгийн зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал:

- ✓ Аудитаар нийт 15,118.7 мянган төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрснээс 7,993.0 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 7,125.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сан:

- ✓ Аудитаар нийт 92,245.6 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрснээс 46,122.8 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 46,122.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

Хоршоо хөгжүүлэх сан:

- ✓ Аудитаар нийт 10,783.3 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан байна.

Тохижилт үйлчилгээний газар:

- ✓ Аудитаар нийт 1 зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлсэн.

3.2.2 Улсын төсвийн байгууллагуудад илэрсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт: нутгийн байгууллагуудад илэрсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт:

Аудитаар нийт 36,762.4 мянган төгрөгийн 11 алдаа, зөрчил илэрснээс 28,335.0 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 162.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 3,569.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага, 4,695.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлсэн байна.

Эрүүл мэндийн төв:

- ✓ Алдаа зөрчил илрээгүй байна.

Соёлын төв:

- ✓ Алдаа зөрчил илрээгүй байна.

ЕБ-ийн сургууль:

- ✓ Аудитаар нийт 34,465.0 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрснээс 27,970.1 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 162.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,637.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 4,695.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

Хүүхдийн цэцэрлэг:

- ✓ Аудитаар нийт 2,297.4 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс 364.9 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 1,932.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгалгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга дүн	1	3,783.1	1	3,783.1			1	3,783.1		
ЗДТГ	1	5,334.0			1	5,334.0	1	5,334.0		
ИТХ	1	7,993.0	1	7,993.0			1	7,993.0		
ОНХС	1	46,122.8	1	46,122.8			1	46,122.8		
ХХС	2	10,783.3			2	10,783.3	2	10,783.3		
Тохижилт үйлчилгээ	-	-	0	0.0	0	0.0	0	0.0		
Орон нутаг дүн	5	70,233.1	2	54,115.8	3	16,117.3	4	24,110.3		
ЕБС	1	27,970.1			1	27,970.1	1	27,970.1		
СӨБ	2	364.9			2	364.9	2	364.9		
Соёлын төв	-	-	0	0.0	0	0.0	0	0.0		
ЭМТ	-	-					0	0.0		
Улсын төсөв дүн	3	28,335.0	-	-	3	28,335.0	3	28,335.0		
Дүн	9	102,351.2	3	57,898.9	6	44,452.3	9	102,351.2		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга дүн	2	63,430.0			1	20,000.0	1	43,430.0
ЗДТГ	5	33,726.5	1	1,124.5	3	27,800.0		
ИТХ	2	7,125.7			2	7,125.7		
ОНХС	1	46,122.8			1	46,122.8		
ХХС	-	-	-	-	-	-	-	-
Тохижилт үйлчилгээ	1	-			1	-		
Орон нутаг дүн	9	86,975.0	1	1,124.5	7	81,048.5	-	-
ЕБС	5	6,494.9	1	162.9	3	1,637.0	1	4,695.0
СӨБ	3	1,932.5			2	1,932.5	1	-
Соёлын төв	-	-	-	-	-	-	-	-
ЭМТ	-	-						
Улсын төсөв дүн	8	8,427.4	1	162.9	5	3,569.5	2	4,695.0
Дүн	19	158,832.4	2	1,287.4	13	104,618.0	3	48,125.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 25

Дугаар 280-А/2371043
ХЭА-2026/005/НА-СТА-ТТЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шинээр эхлэх 48 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Гүн өрмийн худгийн цооног" төсөл, арга хэмжээг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар он дамжуулан хэрэгжүүлэхээр төлөвлөхдөө санхүүжилтийг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багаар тооцож төлөвлөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5-д "шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах," Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 3.3.4.2-д "шинээр эхлэх барилга байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлдэггүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал," гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль, журамд заасан төсөвлөлтийн шаардлагад нийцүүлж хөрөнгө оруулалтын төсөв, арга хэмжээг төлөвлөдөггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга /С.Ганбат/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Ж.ГАНБААТАР
Т.АЛТАНШАГАЙ

